

**МОНГОЛ ТОГЛООМЫН СОЁЛ ХИЙГЭЭД  
ТЭНГЭР, ЛУС САВДГИЙН ШҮТЛЭГ**

**Г.Нандинбилиг<sup>1</sup>**

Монгол угсаатны оюуны соёлын нэгэн өвөрмөц уламжлал бол монгол тоглоом бөгөөд тоглоомын олонх нь ангуучин, малчин ахуй үеийн амьдралын тусгал болж, ан ав хийх, мал сүргээ маллах, арилжих зэрэг хөдөлмөрийн үйл ажиллагаатай холбогдож байдаг ч хөлөгт тоглоомын олонх нь нутаг усаа хамгаалах, газар нутгаа тэлэх цэрэг дайны арга ажиллагааг бэлгэдэж, “Хөзөр”-ийн төрлийн тоглоомын хувьд энх цагийн амьдрал, амар амгаланг бэлгэдэж байдаг.

Монгол тоглоом нь хүмүүний амьдрал, үйл ажиллагааг загварчилж, тэнгэр, лус савдаг зэрэг хийсвэр ертөнцийн нөлөө, ивээл өршөөлд сүсэглэх санаа ямагт зэрэгцэж байдаг. Бидний үзэхээр монгол тоглоом наадмын зүйлсийн олонх нь эрт үедээ зан үйл, шүтлэгийн шинжтэй байсан бөгөөд өдгөө ч тэр шинжээ хараахан бүрэн алдаагүй, сэргээн үзэх боломжтой байгаа юм.

Бид энэ удаад монгол тоглоомын зан үйл дэх тэнгэр, лус савдаг зэрэг хийсвэр ертөнцтэй харьцах домог шүтлэгийн ул мөр нэн сонирхолтой бөгөөд үүнийг тоглоомын

1. Тоглоомын хорио цээр
2. Тоглоомоор домнох уламжлал
3. Тоглоомын бэлгэдэл хийгээд түүний дүрсийн бэлгэдэл

гэсэн гурван талаас нь сэргээн судлахыг зорьсон юм.

Монгол тоглоомын наадах тоглох цаг хугацал, журам дэг нарийн бөгөөд олонх нь тэнгэр хийгээд лусын шүтлэгтэй шууд холбогдсон олон хорио цээрийг үүсгэсэн байдаг. Тоглоомын олонх нь тоглох цаг хугацлын тухайд “тэнгэрийн дуутайд тоглож болохгүй” гэсэн цээртэй бөгөөд хамгийн түгээмэл нэг тайлбар нь “тэнгэр хилэгнэнэ, аянга бууна” гэсэн сүсэг бишрэл юм. Тухайлбал, эртний монголчуудын “Жил” тоглоомоос үүдэлтэй “Хорло” тоглоомыг тэнгэрийн дуутайд тоглох нэн цээртэй. Өвөл ус гол хөлдөж, Лус ичихээс наана “Хорло” дэлгэхийг ихэд хориглож, хавар цагаан сарын шинэдээр ахан дүүсээрээ дэлгэн тоглоод дараагийн өвөл болтол хураадаг. Энэ нь тус тоглоомд луу, могой, хангарьд гээд тэнгэр, лусын амьтдын дүрс орсон тул тэнгэр лусын амьтдаар наадвал лус хилэгнэнэ, тэнгэр задарна”<sup>2</sup> гэсэн үзэл итгэл, сүсэг бишрэлтэй холбоотой юм. Харин мал ахуйн хөгжлийн тусгал болсон шагай тоглоомын хувьд тэнгэртэй шууд холбосон хорио цээрийн зүйл харьцангуй бага бөгөөд зөвхөн “Шагалцах” наадмыг тэнгэрийн дуутайд хориглодог. Энэ хорио цээрийн үндэс нь шагалцахтэнгэр өөд сум шидэж шагайгаа шүүрэх ёстой холбоотой. Тэрхүү сум гэдэг нь эртний баатрын хөө

<sup>1</sup> МУИС-ийн Монгол хэл, соёлын сургууль.

хуягийн тасархай байдаг бөгөөд тэнгэрийн дуутай цагт тэнгэр өөд сум шидэхээр тэнгэрээс аянга бууна гэж үздэг байна.

Тоглоомыг дэлгэж наадах ёстой чухам цаг үе бол хамаг тэнгэр бурхад, харсан юм бүхэн бууж эргэдэг хаврын тэргүүн сарын шинэд юм. Монголчууд цагаан сарын шинийн нэгний өдөр бэлгэтэй сайхан тоглоом дэлгэж, тэр тоглоомоороо дамжуулан тэнгэр, бурхан, лус савдагтай дам холбоо тогтоож, гэрийн жавар үргээх зан үйл байдаг. “Шинийн нэгний өдөр өлзий дэмбэрэл бүрдсэн тоглоом дэлгэж, наргиж цэнгэвэл **гэрийн тэнгэр, Заяан тэнгэр** баясаж, гэрийн жавар үргэдэг<sup>3</sup> гэж итгэх энэ үзлийн нөгөө талд тоглоомд хэр азтай одтой байгаагаар тэр жилийн аз хийморь, ноён нурууг шинжих ёс байдаг. Шинийн нэгэнд тоглоомд хожсон хүн тэр жилийг эрүүл саруул, аз хиймортой сайн давах, онд мэнд орох юм байна, **тэнгэр бурхан** харж байна хэмээн бэлгэшээдэг бол тоглоомд тэнцэх буюу “хайнцвал”, “хавантай байна”, “барцад саадтай байна” гэж үзээд “хавангаа хагалах” буюу барцад саадыг арилгах дом засал болгож, заавал дахин тоглох зэрэг өвөрмөц зан датхалууд буй. Ийнхүү сар шинийн өдрүүдэд тоглоом нь тоглогч этгээдийн барцдыг бэлгэдлээр арилгах, жилийн цээр гаргах зэрэг дом заслын үүрэгтэй болдог.

Цаашилбал, Хорло, үүчүүр зэрэг хөзөр хэлбэрийн тоглоомыг дөрвөлжлөн бэлтгэсэн хусны үйс болон хус модоор хийдэг нь ч тэнгэр шүтлэгтэй холбоотой<sup>4</sup>. Хус модыг монголчууд тэнгэрийн мод гэж үзэж, тэнгэр шүтлэгтэй холбогдох аливаа зан үйлд өргөн хэрэглэдэг.

Дэлхий даяарын эзэн болсон нэгэн тэнгэрийн тухай санаа нь улам баяжиж, тусгай мэргэшсэн үүрэг бүхий олон тэнгэртэй болсны гэрч болсон тоглоомууд бас байна. Жишээ нь арилжаа наймааны соёлыг тусгасан “Дөрвөн хошуу малын заяа”, “Үүчүүр” зэрэг тоглоом нь малын тэнгэр болох **Заяагач тэнгэрийн шүтлэг** хийгээд эдийн тэнгэр болох **Элбэг цагаан тэнгэрийн**<sup>5</sup> шүтлэгтэй холбогдож буй бол, ан агнуурын соёлыг тусгасан “Буга” тоглоом бол ан агнуурын тэнгэр **Манаахан тэнгэрийн** шүтлэг хийгээд Хөхдэй мэргэний домогтой холбогдож байдаг.

Тоглоомын нэр	Тоглох цаг хугацаал, зан үйл	Ахуй, соёлын тусгал	Бэлгэдэх сэтгэлгээний үндэс	Холбогдох аман зохиол
Алаг мэлхий	-Битүүний үдэш од түгэхэд -Булаг ус тахихад -Хотны даллагад	Мал ахуйн соёл	Өнгийн бэлгэдэл, зүгийн бэлгэдэл	Ертөнцийн үүслийн домог
Жил (Хорло...)	- Ураг садан учран золгоход -Шинэ сараар айлчин гийчин	\Бурхны шашны дэлгэрэл\	Дүрсийн бэлгэдэл, Амьтны бэлгэдэл \хулгана бол эд баялгийг хураах	Арван хоёр жилийн магтаал, гуншин

<sup>3</sup> Хөвсгөл аймгийн Шинэ-Идэр сумын харьяат Лханаагийн Сосороос 1998 оны 7 сарын 18 -нд тэмдэглэж авав.

<sup>4</sup> Хөвсгөл аймгийн Шинэ-Идэр сумын харьяат Пүрэвийн Ванчингаас \ 68 настай\ 2007 оны 5сарын 13- нд тэмдэглэж авав.

<sup>5</sup> Хөвсгөл аймгийн Шинэ-Идэр сумын харьяат Лханаагийн Сосороос \ 73 настай\ 1998 оны 7 сарын 18-нд тэмдэглэж авав.

	зочлоход		бэлгэдэл г.м\	
Үүчүүр	-Цагаан сараар ураг садан учран золгоход	Арилжаа наймааны соёл	Амьтны бэлгэдэл, 8 тооны бэлгэдэл	Дом шившлэг, бэлгэ дэмбэрлийн үг
Буга	- Ан авд мордоход - Өвчний цээр гаргахад	Ан агнуурын соёл	Буга урт настай амьтан, Бугын дуу сонсвол урт насална	“Баруун өндөр уул”, “Өндөр хангайн буга” ардын дуу, “Хорин дөрвөн салаа эвэртэй хоо дөнөн буга” тууль г.м

Эртнээс нааш аливаа соёлын уламжлалд тэнгэр бурхдынхаа дүрийг хийсвэрлэн төсөөлснөөр зураг дүрсийн урлагийг үүсгэсэн байдагчлан монголчуудын тэнгэр лус савдаг хийсвэр ертөнцийн шүтлэг нь хээ дүрс, тамганы соёлоор дамжин бидний өгүүлэн буй тоглоомын соёлд нэвтэрсэн байдаг. Жишээлбэл, Эртний монголчуудын жарны системийн цаг тооллын амьтан дээр үндэслэсэн Жил тоглоомын дээд модны хээ дүрсэд **Наран тэнгэрийг** бэлгэдэх “Онги”, **тэнгэрийн** зарлигийн бэлгэдэх “Хас” хээ ахалж байснаа хожим Буддын шашны нөлөөгөөр цагийн мөнхийн хөдөлгөөнийг хүрдээр бэлгэдсэн дүрс болох хорло, гурван цагт энх оршихуйн бэлгэдэлт “Чандмань” болон орон зай цаг хугацлын цогц бэлгэдэлт дүрс “Өлзий”, Энэтхэг домгийн **Вишнү тэнгэрийн хөлөг гарьд \Гаруда\** шувууг дүрслэх болсон байна. Эдгээр хээ дүрс нь монгол гэрийн соёлтойгоо нэгдэн хосолж, гэрийн тэнгэрийг баясгах бэлгэдэлт холбоог үүсгэн байдаг байна. Тодруулж хэлбэл, Наран тэнгэрийг бэлгэдсэн дүрс болох онги нь бурхны шашин нэвтрэх үед цагийн хүрдийг бэлгэдсэн хорло дүрсэд бэлгэдэл утгаа шилжүүлэн идээшүүлж, улмаар монгол гэрийн тооныг бэлгэдэх болсон бол монгол гэрийн ханыг хас тэмдэгтэй адилтгах санаа нь өлзий хээндээ дамжсан байх жишээтэй бөгөөд улмаар тухайн тоглоомыг дэлгэн наадсанаар **гэрийн тэнгэр** баясдаг гэж итгэх болжээ. **Наран тэнгэр** бол барууны тавин таван тэнгэрийн сүлд тэнгэр бөгөөд энэ бол МНТ-нд Алангуа эхийн хэвлийг илсэн Наран тэнгэр мөн бөгөөд хожуу үеийн зохиолуудад “Наран эцэгт, саран эхт монголчууд” гэж гардгийн Наран эцэг мөн болох тухай С.Дулам нарын судлаачид тэмдэглэсэн байдаг.

Тоглоомын хээ дүрсийн тухайд ийнхүү бага сага хувирсан байх боловч хийсвэр ертөнцөд хандах утга бэлгэдэл нь бараг өөрчлөгдөөгүй байна. Чухамхүү энэ чанараараа монгол ардын наадам нь археологийн олдвор шиг биет бөгөөд хорио цээр ба дүрсийн бэлгэдлээр дамжуулан тэнгэр, бурхан, лус савдаг зэрэг хийсвэр ертөнцийн тухай үзэл бишрэлээ мэдээлж байдаг үнэт судлагдахуун юм.

Цаашилбал, нялхсын наадгайн соёлд ч тэнгэр бурхан, хийсвэр ертөнцийн шүтлэг ажиглагдаж байна. Нялхсын наадгайд эсгий үнэгээс эхлээд есөн нүх, тээнгэ, зоос, өлзий зангилаа, загасан нуруу, эр эм явуу, хушга, гахайн голхи, тойг, шагай болон чоно, буга, үнэг, адуу зэрэг амьтдын жижиг сийлбэр, хаш зэргийг нарийн сураар хэлхэн зүүж, бэлгэдлийн чуулган бүтээдэг. Эдгээр наадгайн зүйлс нь дор бүрээ бэлгэдэл утгыг хадгалж, тэнгэр бурхан, онгод зэрэг ямар нэгэн хийсвэр ертөнцийн ээл ивээлийг төлөөлсөн тусгай дом болж, хүүхдийг сахин хамгаалж байдаг.

Наадгайн зүйлс	Бэлгэдэл	Хандаж буй хийсвэр ертөнц	Дом
Эсгий үнэг		Ад элиэ	Ад элиэг эндүүрүүлэх дом
Бэл	Төрийн хар хүн	Төрийн сүлд	
Есөн нүх,	9 тоо	Мөнх тэнгэр	Таниулах дом
Онгин ба дөрвөлжин тээнгийг эрэгтэй хүүхдэд	Газар нутгийн эзэн суух	Наран тэнгэр	Гэмтэх бэртэхээс хамгаалах дом
Саран ба гурвалжин тээнгийг эмэгтэй хүүхдэд	Нутаг ус	Саран тэнгэр	
Зоос	Бэл бэнчин	Эдийн тэнгэр	Эд баялаг дуудах дом
Өлзий зангиа	Ам бүлийн бат холбоо	Ургийн тэнгэр	Амь насыг зангидах
Загасан нуруу	Нурууг бэлгэдэх	Лус	Усны аюулаас хамгаалах
Эр эм явуу	Цэвэр ариуныг		Энхэр хүүхдийг хамгаалах
Хушга	Эр бэлгийг	Эцгийн тэнгэр	Удам залгах дом
Гахайн соёо, голхи	Газар нутаг гуйх	Газар эх, \Лус савдаг\	Лус савдагийн хорлолоос хамгаалах дом
Жижиг цоож	Амь насыг цоожлох	Заяагч	Ороодог хүүхдийг тогтоох
Жижиг нум сум	Мэргэн харваач болохыг	Ангийн тэнгэр	Муу юмыг айлгах дарлагын дом
Чоно	Сүлд хийморийг	Чоно тотем	Аз хийморьтой явах
Буга	Урт насыг	Буга тотем	Урт наслах
Адуу	Хүлэг унааг	Унааны тэнгэр	Унаатай явах
Эрхий ороох сур	Адуу малтай болох	Адуу малын тэнгэр	Адуу малтай болох

Эдгээрээс хамгийн анх эсгий үнэгийг хүүгийн эцэг, эсвэл нагац нь өөрийн гараар хайчлан зүүж өгдөг домтой. Бусад нь хүүхдийн угаалга мялаалгын зан үйлтэй холбоотой бөгөөд хүүхдийн угаалганд уригдсан хүүхдүүд хийж авч ирдэг заншилтай. Хүүхдийн угаалга гэдэг бол **Милаан тэнгэрт** таниулах ёслол бөгөөд энгийнээр хэлэхэд нялхсыг төрөөд гурав хоноход борви тойгны шөлөөр угаан, хүүхдэд нэр өгөх ёс юм. Энэ бүхнээс дүгнэж үзэхэд

1. Монгол тоглоомын соёл нь дом шившлэг, хорио цээр хийгээд дүрсийн бэлгэдлийн чинаддаа тэнгэр, бурхан, лус савдагийн шүтлэгээ хадгалж ирсэн үнэт судлагдахуун болно.
2. Монголчуудын тэнгэр шүтлэг нь хээ дүрс, тамганы соёлоор дамжин бидний өгүүлэн буй тоглоомын соёлд уламжилсан байна.

3. Монголчууд нүдэнд үл үзэгдэх хийсвэр ойлголт болох тэнгэрийнхээ дүрийг дүрслэхдээ ямар нэгэн амьд төрөлхтний төрх байдлаар төсөөлөн хөрөглөх бус, харин тодорхой хээ дүрсээр бэлгэдэн төлөөлүүлж ирсэн нь монгол тоглоомын соёлоос харагдаж байна.

### НОМ ЗҮЙ

1. БНМАУ-ын угсаатны зүй: Халхын угсаатны зүй. XIX-XX зуун. Улаанбаатар 1987
2. Дарамбазар Х. Монгол ардын тоглоом. Үнэн 1989.03.11 №60
3. Дулам С. Монгол домог зүйн дүр. Улаанбаатар 1989
4. Дулам С, Нандинбилиг Г. Монгол аман зохиолын онол. Улаанбаатар 2007
5. Намжилдорж Н. Монгол ардын хөлөгт тоглоом. Боть I. II, Улаанбаатар 1963, 1966
6. Нандинбилиг Г. Монгол тоглоомын зан үйл, бэлгэдэл. “Нүүдэлчдийн өв” Монголын үндэсний музейн ЭШ-ний сэтгүүл. Tomus VIII, Fasc17, 190-202 тал, Улаанбаатар 2008
7. Нандинбилиг Г. “Буга” тоглоомын зан үйл, бэлгэдэл. “Монгол судлалын чуулган”. МУБИС-ийн эрдэм шинжилгээний цуврал. № 7 /42/, 143-150 дахь тал, Улаанбаатар, 2009
8. Nandinbilig G. Symbolic and ritual qualities of the Mongolian games. Study of Mongolian Symbolism Quest and Perspectives. Papers and abstracts. p. 52-54, International Conference 8-10 September 2009, Ulaanbaatar

### SUMMARY

Archaeological findings show that Mongol traditional games are derived from tangible cultural heritage; they dictate worship and belief in spiritual and everyday matters through taboos and symbolic imagery from the games. Therefore, games are valuable objects of research in further understanding Mongol culture.

1. Mongol games are valuable objects of research, preserving traditional beliefs about taboo and magic, and their symbolic imagery shows belief in heaven and worship of deities and spirit lords of land and water;
2. The cult of *tenger* 'heaven' has an observable influence on games through patterns, images and cattle marking;
3. It is evident from the customs of some Mongol games that Mongolians represented the invisible deities not with anthropomorphic drawings, but symbolically through patterns and shapes.